

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ТАЙЛАН

2025.12.20

Д/д	Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ						
1	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулж, гудамж, зам талбай, гэмт хэргийн эмзэг цэгийг хянах “Камерын хяналтын дэд төв”-ийг ашиглалтад оруулах.	Хэрэгжилтийн хувь	0	100	Гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээлэл өсч байгаа хороодод гэмт хэрэг, зөрчил, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ард иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, бэлэн байдлыг ханган зөөврийн “Пост” байршуулж ажиллаж байна. Гэмт хэргийг буруулах ажлын хүрээнд “Аюулгүй орчин” аян зарлаж урьдчилан сэргийлэх ажлыг 5 чиглэлээр зохион байгуулсан. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага иргэн аж ахуйн нэгжид шаарлага-112, зөвлөмж-78 тус тус өгч үр дүнг тооцож, шаардлага биелүүлээгүй 4 иргэн, 3 албан тушаалтныг нийт 5.3 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авч ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Теле камерын хяналтын дэд төв” 12 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр өдөр тутмын ажиллагаагаа хэвийн явуулж байна. Тус төвд өнөөдрийн байдлаар дүүргийн Цагдаагийн газрын 1, 2, 3 дугаар хэлтсээс тус бүр нэг албан хаагч 24 цагаар ажиллаж байгаа бол Нийслэлийн мэдээлэл, шуурхай удирдлагын төвөөс нэг ажилтан дуудлага, мэдээллийг тухай бүр шууд хүлээн авч, холбогдох байгууллагад цаг алдалгүй мэдэгдэн ажиллаж байна. “Теле камерын хяналтын дэд төв”-д нийт 165 ширхэг камер бүртгэлтэй байгаагаас хэвийн ажиллагаатай 133 ширхэг камер байна. Камерын хяналт бүхий “Ногоон бүс” байгуулах ажлын хүрээнд дүүргийн 12, 18, 33 дугаар хороодыг камержуулах ажлын зураг, төсөв боловсруулах ажил хийгдэж байна.	100%

2	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авто замын ачааллыг бууруулахад чиглэсэн хөдөлгөөн зохицуулалтын арга хэмжээ авч ажиллах.	Хэрэгжилтийн хувь	100	100	<p>Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, 15 цэгт, 2 ээлжээр нийт 65 алба хаагч тогтмол үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Замын цагдаагийн цагдаагийн албан хаагчид дунд “Цамба-Уриалга” Viber групп үүсгэн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг мөрдүүлж, иргэд, олон нийттэй зөв боловсон харьцаж, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар уриалгад нэгдэн, түргэн шуурхай ажиллаж байна. Тайлант хугацаанд гудамж, замын хяналт шалгалтаар согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 1711, эрхийн үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 1294 зөрчлийг илрүүлэн нийт зөрчил гаргасан 90,590 жолоочийг 2.1 тэрбум төгрөгөөр торгох арга хэмжээг авч хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажилласан. Эргүүлийн чиглэл, харуулын цэгт үүрэг гүйцэтгэх алба хаагчдын чиг үүргийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 12 цэгт, 2 ээлжээр нийт 41 алба хаагч тогтмол үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.</p> <p>Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Зөрчилгүй жолооч”, “Сигнал”, “Уусан бол бүү жолоод”, “Дураараа биш дүрмээрээ”, “Явган зорчигч” гэсэн нэгдсэн болон хэсэгчилсэн нөлөөллийн арга хэмжээг дүүргийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Тус арга хэмжээнүүдийн хүрээнд зөрчил гаргасан нийт 11,727 жолоочид Зөрчлийн тухай хуулийн дагуу 240.5 сая төгрөгийн торгууль ногдуулсан. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1260 зөрчил, эрх хасагдсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 969 зөрчлийг тус тус илрүүлсэн.</p>	90%
3	Дүүргийн 21, 40 дүгээр хороонд гал түймэр унтраах, аврах анги байгуулах ажлыг үргэлжлүүлнэ;	Хэрэгжилтийн хувь	70	100	<p>Дүүргийн 21 дүгээр хороо, Жаргалант тосгонд 1.1 га талбайд шинээр Гал түймэр унтраах, аврах 82 дугаар анги байгуулах ажил нь нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, барилгын гүйцэтгэгчээр “Эй Эс Эс инженеринг” ХХК шалгарч барилгын газар шороо, бэлтгэл бетоны ажил бүрэн хийгдсэн суурь цутгалт, карказ угсаралтын ажил</p>	90%

					хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 30 хувьтай хуваарийн дагуу явж байна. Дүүргийн 40 дүгээр хороонд шинээр “Гал түймэр унтраах, аврах 29 дүгээр анги”-ийг шинэчлэн байгуулах ажил нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж байна. Барилгын гүйцэтгэгчээр “Энигма” ХХК ерөнхий карказ, бүтэцийг бүрэн хийсэн, барилгын гадна, дотор засварын ажлын гүйцэтгэл хангалтгүй барилгын ажил хойшлогдон тул гэрээг 3 удаа сунгасан. Ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.	
4	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавхыг сайжруулна;	Хэрэгжилтийн хувь	100	100	<p>Онцгой байдлын хэлтсээс энэ онд гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ангиллын сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Оюутан, сурагчдын сургалтыг 33 удаа; • Иргэдийн сургалтыг 23 удаа; • Удирдах ажилтны сургалтыг 5 удаа; • Мэргэжлийн ангийн сургалтыг 8 удаа; • Ажилтан алба хаагчийн сургалтыг 343 удаа нийт 412 удаагийн сургалтыг зохион байгуулж, 18,945 хүнийг хамруулсан. Ангиллын сургалтын үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50.6 хувиар өссөн. <p>Гал түймэр, гоц халдварт өвчин, Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 253 удаа давхардсан тоогоор 3,256 алба хаагчдыг хамруулж, 102,674 айл өрх, 189,326 иргэнд урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг хүргүүлсэн. Сэргийлье, сэрэмжлье, галлахдаа анхаарья нөлөөллийн ажлын хүрээнд 78 контентийг бүтээж, 168,913 иргэнд түгээсэн. Нийт 38 аж ахуй нэгж, байгууллага, 109-н сургууль, цэцэрлэгт гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, зөвлөмж, төлөвлөгөө боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавхыг сайжруулах зорилгоор Сонгинохайрхан дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн зардлаар ой хээрийн түймрийн үед ашиглах туулах чадвар сайтай “Танк 300” автомашин, үерийн үед хүн хүч багаж хэрэгслийг зөөвөрлөх давхар кабинтай “Портер” автомашин, шалган нэвтрүүлэх товчоодод үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад “Хөдөлгөөнт удирдлагын байр”, үерийн үед ашиглах “Угсардаг далан” зэргийг шийдвэрлэсэн.</p> 	100%

					Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс үер ус, халиа тошин хүндэрсэн үед ашиглах нураагч модок, мөсний гинжин хөрөө, мөрөвчтэй усны гутал, гар багаж /хүрз, лоом, жоотуу/ зэргийг тус тус шийдвэрлэсэн. Сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор офицер бүрэлдэхүүний сургалтыг 5, ахлагч бүрэлдэхүүнд 30, төрөл мэргэжлийн сургалтыг 5, тактик тархалтын сургалтыг 144 удаа тус тус зохион байгуулж нийт давхардсан тоогоор 2700 алба хаагчийг хамруулсан. Алба хаагчдын Хууль, эрх зүй, цэргийн хэргийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг цахим хэлбэрээр нийт 4 удаа авч давхардсан тоогоор 260 алба хаагч хамрагдсан.	
5	Хууль, хяналтын байгууллагын байр, барилга байгууламжийн засвар үйлчилгээ, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, техник, тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна;	Хэрэгжилт ийн хувь	100	100	Хууль, хяналтын байгууллагын байр, барилга байгууламжийн засвар үйлчилгээний чиглэлээр дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн байрны дээвэр, гадна фасад засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хууль, хяналтын байгууллагын алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, техник, тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр: <ul style="list-style-type: none"> • 32 ширхэг иж бүрэн компьютер, 4 ширхэг өнгөт принтер, 32 ширхэг оффис ширээ, 32 ширхэг сандал, • Зөөврийн пост зэргийг шийдвэрлэж ажилласан Дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Уулзалт, мэдүүлэг авах 9 өрөө, Цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн 7 өрөө, Цагдаагийн газрын гуравдугаар хэлтсийн 6 өрөөг мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлагад нийцүүлэх засваралсан. Зөөврийн кобоныг Шинэлэг сууц ХХК-аар гүйцэтгүүлж, 18 дугаар хороо Таван шарын автобусны буудал дээр байрлуулж, дүүргийн эрчим хүч хэрэглэгчид үйлчлэх төвөөс цахилгаан тэжээлд холбосон. Тус кобанд өдөр бүр явган эргүүлийн 1 чиглэлийн 2 алба хаагч үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Алба хаагч нарын ажиллах орчин нөхцөлийг сайжруулан ширээ сандал бусад хэрэгслээр хангасан. Дүүргийн Прокурорын газрын албан хаагчдын аюулгүй байдлыг хангах, ажиллах нөхцөлийг хэвийн явуулах үүднээс 5ш энгэрийн камерыг шийдвэрлэсэн.	100%
6	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран иргэд, олон нийт, албан хаагчдын эрх зүйн	Хэрэгжилт ийн хувь	100	100	Хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээний хандлагыг төлөвшүүлэх	100%

	боловсролыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, тэдний оролцоог нэмэгдүүлнэ.				зорилгоор хороодын хөгжлийн нийгмийн ажилтнууд болон хэсгийн ахлагч нарт “Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ” сургалт, хэлэлцүүлгийг Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран танхимаар болон цахим сургалтыг зохион байгуулж нийт 422 албан хаагчдыг хамруулсан. Нийслэлийн захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн Тамгын газартай хамтран шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, иргэдийн шүүх хуралдаанд оролцох ач холбогдлыг таниулах, тэдгээрийн идэвхийг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулж 34 иргэнд хамрагдсан. Мэйжик Эй Эм Ди ХХК-тай хамтран хүүхэд болон насанд хүрсэн иргэдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор теле контент, богино хэмжээний видео 2, постер 1-ийг гарган нөлөөллийн ажлууд хийгдэж байна.	
7.	Арга хэмжээ 1.7. Дээд газраас ирүүлсэн тогтоол шийдвэрт хяналтын карт үүсгэж, хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тооцох, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх.	Хяналтад авсан шийдвэрийн тоо	25	21	2025 оны тайлант хугацаанд Монгол Улсын хууль-2, 4 заалт, Монгол Улсын Засгийн газрын тогтоол-3, 7 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-4, 6 заалт, Засгийн газрын албан даалгавар-2, 7 заалт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл-6, 13 заалт, Нийслэлийн Засаг дарга, ХЗДХЯСайдтай байгуулсан гэрээ-4, заалт-3 нийт 21 тогтоол шийдвэрийн 40 заалтыг хяналтад авч, биелэлтийг хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.	100%
		Хэрэгжилтийн хувь	93,7	100		
8	Арга хэмжээ 1.8. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрт хяналтын карт үүсгэж, хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тооцох, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх.	Хэрэгжилтийн хувь	91,8	100	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас хяналтад авсан нийт 15 тогтоолоос 15 заалтыг хяналтад авч, холбогдох нэгжүүдэд хүргүүлэн танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийг тооцох, биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.	100%
ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ						

9.	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.	Хэрэгжилт ийн хувь	86,7	95-ээс дээш	Дүүргийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тус хэлтсээс Иргэдийн аюулгүй амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулж, мэргэжлийн байгууллага, албан хаагчдын чадавхыг бэхжүүлж, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр нийт 6 үйл ажиллагааг төлөвлөсөн оруулж, 2025 хэрэгжилтийг ханган биелэлтийг гаргасан.	100%
10.	Дүүргийн эрх зүйн орчныг судлах, боловсронгуй болгох, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай хууль, дүрэм, журмын төсөл боловсруулах, санал авах;	Хэрэгжилт ийн хувь	0	100	2025 оны эхний хагас жилийн байдлаар дараах хууль болон журмын төсөлд санал авч нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хууль; • Дампуурлын тухай хуулийн төсөл; • Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл; • Мансуурлын тухай хуулийн төсөл; • Арилжааны тухай хуулийн төсөл; • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл; • Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл; • Зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт; • Мэдээлэл хариуцагчийн журмын төсөл; • Хууль зүйн туслалцааны төвийн нийслэл болон орон нутаг дахь салбарын ажлын байранд тавих шаардлага стандартын төсөл; • Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай, Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл. 	100%
11.	Иргэдийг хүлээн авч эрх зүйн туслалцаа үзүүлэн, мэдээлэл өгөх, холбогдох байгууллагад холбон зуучлах.	Үйлчлүүлс эн иргэдийн тоо/хувь	28	40	Тайлант хугацаанд байгууллагын нэр бүхий 2 ажилтан, мөн хүүхэд үрчлэлт болон гэр бүлийн асуудалтай холбоотой 6 иргэн. Мөн 12, 14, 21, 32, 33 дугаар хороодоос зөвлөгөө, мэдээлэл авсан.	100%

12.	Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлүүлэх, ярилцлага хийлгэх;	Албан хаагчийн тоо	4	4	2025 оны эхний улирлын ярилцлагыг хэлтсийн хэмжээнд 2025.04.07-ны хэлтсийн албан тушаалтнуудтай хийсэн. 2025 оны 3 дугаар улирлын ярилцлагыг тус хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэнтэй 10 дугаар сарын 20 өдөр хийж, ажлыг эрчимжүүлэх чиглэлээр зөвлөгөө өгсөн.	100%
13.	Хэлтэст ирсэн, явсан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэх шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээлэх.	Албан бичгийн тоо, хэрэгжилтийн хувь	100	100	Тус хэлтэст 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 484 албан бичиг ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээлэж ажилласан.	100%
14.	Албан тушаалын чиг үүргийн дагуу төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх;	Өргөдөл гомдлын тоо, хэрэгжилтийн хувь	100	100	ERP дотоод удирдлагын системээр Иргэдээс 18 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд системийн модуль Edoc-д ирсэн бол цаасаар 6 иргэний өргөдлийг холбогдох байгууллагуудад уламжилж, шийдвэрлэж, хуулийн хүрээнд хариу өгсөн. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасан шийдвэрлэлийн зөрчил байхгүй.	100%
18.	Дүүргийн Засаг даргаас батлан гаргах бодлогын баримт бичиг, шийдвэрийн төсөлд, санал өгөх, хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, биелэлт гаргах;	Хэрэгжилтийн хувь	100	100	Дүүргийн Засаг даргаас батлан гаргах бодлогын баримт бичиг, шийдвэрийн төсөлд, санал өгөх оруулах ажлыг тухай бүр хийж гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд нийт 1418 албан бичгийн төсөлд санал өгсөн ба үүнийг ангилбал: <ul style="list-style-type: none"> • Дүүргийн засаг даргын захирамж А: 701 • Дүүргийн засаг даргын захирамж Б: 98 • Дүүргийн засаг даргын Албан даалгавар: 4 • Дүүргийн засаг Тамгын газрын даргын тушаал А:226 • Дүүргийн засаг Тамгын газрын даргын тушаал Б: 389 	100%
19.	Засаг дарга, Засаг даргын Тамгын газартай холбоотой асуудлаар бусад байгууллагуудтай хэрэг хянан шийдвэрлэх болон бусад ажиллагаанд хамтран ажиллах;	Хэрэгжилтийн хувь	100	100	2025 оны хагас жилийн байдлаар дүүргийн Засаг дарга, Тамгын газартай холбоотой 9 хэрэг маргаан эцэслэгдэн шийдвэрлэгдсэн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар захиргааны-13, нийт 13 хэрэг маргаан шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> -Анхан шатны шүүх-13 үүнээс -Давж заалдах шатны шүүх-0 -Улсын дээд шүүх-0 	100%

20.	Хэрэг маргааныг шийдвэрлүүлэхэд шаардлагатай нотлох баримт бүрдүүлэх, гаргуулах, ажил зохион байгуулах;	Шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтын тоо/хувь	10,115	5,000	Захиргаа, Иргэний хэрэг маргааны ажиллагааны хүрээнд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу 949 хуудас нотлох баримтыг холбогдох газарт хүргүүлсэн.	100%
24.	Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрүүдийг Тамгын газрын хэлтсүүд холбогдох албан тушаалтнуудад сурталчлах, таниулах, мөрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих, гүйцэтгэлийг тооцох, биелэлийг хугацаанд нь хүргүүлэх;	Хэрэгжилт ийн хувь	0	100	2025 оны тайлант хугацаанд Монгол Улсын хууль-2, 4 заалт, Монгол Улсын Засгийн газрын тогтоол-3, 7 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-4, 6 заалт, Засгийн газрын албан даалгавар-2, 7 заалт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл-6, 13 заалт, Нийслэлийн Засаг дарга, ХЗДХЯСайдтай байгуулсан гэрээ-4, заалт-3 нийт 21 тогтоол шийдвэрийн 40 заалтыг хяналтад авч, биелэлтийг хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.	100%
25.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрүүдийг Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагууд болон хороодын холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих, гүйцэтгэлийг тооцох, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх;	Хэрэгжилт ийн хувь	0	100	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас хяналтад авсан нийт 15 тогтоолд хяналтын карт үүсгэн холбогдох нэгжүүдэд хүргүүлэн танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийг тооцох, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.	100%
26.	Дүүргийн Засаг дарга болон дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын бүрэн эрхийн хүрээнд гаргасан захирамж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийг тооцож, биелэлтийг нэгтгэх.	Хэрэгжилт ийн хувь	0	100	Албажин гарсан захирамж, тушаалыг бүртгэлийн дэвтэрт бүртгэж, бүртгэлийг excel файлд шивж нэгдсэн хүснэгтэд оруулах ажлыг хийж гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд <ul style="list-style-type: none"> • Дүүргийн засаг даргын захирамж А: 701 • Дүүргийн засаг даргын захирамж Б: 98 • Дүүргийн засаг даргын Албан даалгавар: 4 • Дүүргийн засаг Тамгын газрын даргын тушаал А:226 • Дүүргийн засаг Тамгын газрын даргын тушаал Б: 389 тус бүр гарсан байгаа эдгээр албан тоотуудын биелэлтийг гаргах ажлыг хийж гүйцэтгэж байна. 	
ГУРАВДУГААР ХЭСЭГ. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ						
27.	Засаг даргын Тамгын газрын ажилчдын боловсруулж буй гэрээний төслийг хянах, хуульд нийцүүлэн санал оруулах;	Хянасан гэрээний хувь	0	100	Тайлант хугацаанд нийт 735 гэрээг иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан ба эдгээр бүх гэрээний төслийг хянах, хуульд нийцүүлэн туахй бүр санал оруулсан.	100%

28.	Засаг дарга болон түүний эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын актын хууль зүйн үндэслэлийг хянах;	Хэрэгжилт ийн хувь	0	100	Захиргааны акт гаргахдаа иргэний эрх ашиг хөндөгдсөн эсэхэд Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлүүдэд заасны шийдвэрийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу 2 сонсох ажиллагааг явуулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна	100%
29.	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хуулийн мэргэжилтэнд зориулсан сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.	Хамрагдах албан хаагчийн хувь	0	100	Дүүргийн Засаг даргын 01 дүгээр албан даалгавар хүрээнд А/193 дугаар захирамжаар баталсан удирдамжийн дагуу дүүргийн Нийгмийн даатгалын газар, Татварын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг шалган, зөвлөх ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 03-16-ны өдрүүдэд зохион байгуулсан. Мөн дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, мэдээлэл сургалтын төв болон бусад Засаг даргын эрхлэх асуудлын харьяа, хэлтэс, албанд мэргэшил арга зүйн туслалцаа үзүүлсэн.	100%
30.	Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал, захиргаатай холбогдсон асуудлаар шүүх, хууль хяналтын байгууллага болон бусад байгууллагад эрх бүхий албан тушаалтын итгэмжлэлээр хэрэг хянан шийдвэрлэх болон бусад ажиллагаанд төлөөлөх;	Хэрэгжилт ийн хувь	100	100	2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар дүүргийн Засаг дарга, Тамгын газартай холбоотой 22 хэрэг маргаанд холбогдох шатны шүүхүүдэд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон бөгөөд үүнээс эцэслэгдэн шийдвэрлэгдсэн 9 хэрэг, нийт шүүх хуралдаанаас захиргааны-21, иргэний-1 нийт 22, үлдсэн 13 хэрэг маргаан шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх шатанд байна. Давхардсан тоогоор нийт 94 удаагийн шүүхийн хэрэг маргаанд хариуцагчаар оролцсон бол газрын маргаантай холбоотойгоор 8 удаагийн газрын үзлэгт явсан. Үүнээс: -Анхан шатны шүүх-8 -Давж заалдах шатны шүүх-86	100%
31.	Дүүргийн Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангах, үр дүнг тооцож тайлагнана;	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	91%	100%	Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажил тайлант хугацаанд хэрэгжээгүй ба 2026 онд хийхээр төлөвлөсөн.	91%
32.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах нөлөөллийн арга хэмжээг иргэд, олон нийтийн дунд зохион байгуулж, сурталчилна.	Зохион байгуулах арга хэмжээ			Гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээлэл өсч байгаа хороодод гэмт хэрэг, зөрчил, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ард иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, бэлэн байдлыг ханган зөөврийн "Пост"	100%

		Хамрагдсан албан иргэдийн хувь	100	100	байршуулж ажиллаж байна. Гэмт хэргийг буруулах ажлын хүрээнд “Аюулгүй орчин” аян зарлаж урьдчилан сэргийлэх ажлыг 5 чиглэлээр зохион байгуулсан. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага иргэн аж ахуйн нэгжид шаарлага-112, зөвлөмж-78 тус тус өгч үр дүнг тооцож, шаардлага биелүүлээгүй 4 иргэн, 3 албан тушаалтныг нийт 5.3 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авч ажилласан. Хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээний хандлагыг төлөвшүүлэх зорилгоор хороодын хөгжлийн Нийгмийн ажилтнууд болон Хэсгийн ахлагч нарт “Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ” сургалт, хэлэлцүүлгийг танхимаар болон цахимаар зохион байгуулж нийт 422 албан хаагчдыг хамруулсан.	
33.	Төрийн албан хаагчдад эрх зүйн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэн, үр дүнг тооцно.	Хамрагдсан албан хаагчдын хувь	100	100	Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад болон Засаг даргын харьяа хэлтэс, нэгжүүдэд тухай бүр хууль, эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгч ажилласан. Дүүргийн Засаг даргын 01 дүгээр албан даалгавар хүрээнд А/193 дугаар захирамжаар баталсан удирдамжийн дагуу дүүргийн Нийгмийн даатгалын газар, Татварын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг шалган, зөвлөх ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 03-16-ны өдрүүдэд зохион байгуулсан. Мөн дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, мэдээлэл сургалтын төв болон бусад Засаг даргын эрхлэх асуудлын харьяа, хэлтэс, албанд мэргэшил арга зүйн туслалцаа үзүүлсэн. Тайлант хугацаанд шинээр батлагдсан хууль тогтоомж болон шинэчилсэн найруулга ирээгүй тул нийт албан хаагчдад мэдлэг олгох сургалт зохион байгуулаагүй.	90%
<p>ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</p>						

34.	Дүүргийн хууль, хяналтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, хамтран ажиллах, мэдээ мэдээллээр тогтмол хангах, үр дүнг тооцох.	Хэрэгжилт ийн хувь	100	100	Дүүргийн Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Замын цагдаагийн хэлтэстсийн холбогдох албан хаагчидтай Viber группээр байнга харилцаж, цаг үеийн асуудлаар болон дүүргийн Засаг даргын шуурхай хуралдаан, Засаг даргын Зөвлөлийн хурал, Нийслэлийн Засаг даргын шуурхай хурлаас өгөдсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэлэлцэн хамтран шийдвэрлэн ажиллаж байна.	100%
35.	Нийтийн хэв журмыг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийг хангах, үр дүнг тооцох, тайлагнах.	Хэрэгжилт ийн хувь	100	100	Дүүргийн Засаг даргын 2025.04.18-ны өдрийн А/239 захирамжийн хүрээнд дүүргийн 43 хороод болон дүүргийн Цагдаагийн газар, Замын цагдаагийн хэлтэстэй хамтран нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллах амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж талбайд удаан хугацаагаар байршуулж бусдын хөдөлгөөнд саад учруулсан иргэдийн тээврийн хэрэгслүүдийг чөлөөлөх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Нийт 145 холбогдох эзэнгүй тээврийн хэрэгслийг түр саатуулах газарт шилжүүлж, тухайн тээврийн хэрэгслийн эд анги, сэлбэг хэрэгсэл хулгайд алдагдахаас сэргийлсэн. Цагаан сар, Наадам зэрэг нийтийн тэмдэглэлт баярын өдрүүдэд дүүргийн хэмжээнд хариуцлага жижүүр ажиллуулж, гарсан хэрэг зөрчлийг тухай хүр холбогдох байгууллагад уламжилж ажилласан.	100%
36.	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мөн архины хамааралтай иргэдэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.	Зохион байгуулса н сургалт, хамрагдса н иргэдийн тоо	2	200	Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн давтамж өндөр дуудлага, мэдээлэлтэй архины хамааралтай 135 иргэдэд "Алдаж боломгүй амьдралын амт" сэдвийн хүрээнд бүлгийн зөвлөгөө, ярилцлагыг 4 удаа зохион байгуулсан. "Хүүхэд хамгаалагч" ахмад ажилтан 68, дүүргийн "Өсвөрийн сэргийлэгч бүлгэм", "Хүүхдийн зөвлөл"-ийн төлөөлөл бүхий 61 сурагч, Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 38 хүүхэд, гэр бүл нийгмийн ажилтантай уулзалт зохион байгуулсан. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн давтамжтай дуудлага мэдээллийг бууруулах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, архины хор уршгийг таниулах чиглэлээр давтамжтай дуудлага, мэдээллийн бүртгэл судалгаанд авагдсан нэр бүхий 75 иргэн болон өөрсдийн хүсэлтээр сургалтад хамрагдахаар ирсэн 20 иргэн нийт 95 иргэнд "Гэр бүлийн Үнэ цэнэ" сэдэвт өдөрлөгийг зохион байгуулж,	100%

					<p>хүрэлцэн ирсэн иргэдээс санал хүсэлтийг авч, хууль зүйн зөвөлгөө авах хүсэлт гаргасан иргэдтэй ганцаарчилсан уулзалт хийсэн. Хүүхэд, Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл давтамжтай ирүүлдэг "Хяналтын хувийн хэрэг"-тэй хохирогч, холбогдогч нарыг дахин гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээлэл ирүүлэхээс урьдчилан сэргийлэх, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Хайр өвтгөхгүй-1" нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж зорилтод 20 гэр бүлийн 60 эцэг, эх, хүүхдүүдийг хамруулсан. "Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх" мөн хариуцсан хороодод бүртгэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хоорондын уялдаа холбоог сайжруулж, хамтран ажиллах зорилгоор нээлттэй уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, дүүргийн хэмжээнд гарч буй гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, хороодод хэрэгжиж буй урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, цаашдын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэ бол архины хамааралтай 135 иргэдэд "Алдаж боломгүй амьдралын амт" сэдвийн хүрээнд бүлгийн зөвлөгөө, ярилцлагыг 4 удаа зохион байгуулсан.</p>	
--	--	--	--	--	---	--